# Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

## Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

## 2022 оны жилийн эцэс

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн явц | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллын үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| МУ-ын хууль | | | | | | | |
| 1 | 2 | Цөмийн энергийн тухай<br>2009-07-16<br>дугаар 2009-07-16 | 15.2. Дараах үйл ажиллагааг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ:<br>15.2.1.цацраг идэвхт ашигт малтмал эрэх, хайх;<br>15.2.2.цацраг идэвхт ашигт малтмал ашиглах;<br>15.2.3.цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах болон цацраг идэвхт ашигт малтмал ашигласны дараа газар нөхөн сэргээх. | 2019 онд Олон улсын атомын энергийн агентлагт “Ураны үйлдвэрлэлийн талбайд үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээ” авах хүсэлтийг Монгол Улсын Цөмийн Энергийн Комиссоос тавьж 2022 оны 05 дугаар сарын 09-20-ны өдрүүдэд Бадрах энержи ХХК-ны Зөөвч-Овоо, Дулаан-Уул төслүүдийн газарт очиж ажилласан. UPSAT-ийн зөвлөх үйлчилгээний баг Монгол Улсын Засгийн газарт цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох, хууль, хяналтын үйл явц зэрэг эрх зүйн зохицуулалтын дэд бүтцийг боловсронгуй болгох, хэвийн үйл ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор нийт 16 зөвлөмж, 14 санал, эрх бүхий төрийн байгууллага болон оператор компанийн нэвтрүүлсэн 4 сайн туршлагыг тусгасан тайланг эцэслэн энэ оны 9 сарын 27-нд ирүүлсэн. Цөмийн энергийн комиссоос /UPSAT/ үнэлгээний багийн хийсэн үнэлгээнээс хэрэгжүүлэх арга хэмжээ, холбогдох төсвийн саналыг авахаар ирүүлсний дагуу саналыг боловсруулж ЦЭК-ийн мэргэжилтэн Э.Нямжавд албан бичгээр хүргүүлсэн.<br>Цөмийн Энергийн Комиссын Ажлын албанаас ирүүлсэн албан бичгийн хүрээнд ОУАЭА-ийн | 70 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | төлөөлөл зөвлөх үйлчилгээний бэлтгэлийг хангах “Ураны боловсруулалтын талбайн үнэлгээний баг”-тай Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт орших Зөөвч овоо, Дулаан уул цацраг идэвхт ашигт малтмалын ордын үйл ажиллагаатай танилцахаар 2022 оны 05 дугаар сарын 13-15-ны өдрүүдэд газар дээр ажилласан.<br>Ашигт малтмал, газрын тосны газар болон Бадрах энержи ХХК-ны хооронд байгуулсан орд ашиглах гэрээний хэрэгжилтийн хүрээнд тус компаниас 2022 оны 11 дүгээр сарын 15, 16-ны өдрүүдэд “Уран ба газар дор уусган олборлолт” сэдэвт сургалтыг зохион байгуулсан бөгөөд Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал, УУХ, КХ, АМХХ, ТУЗГ-аас нийт 12 албан тушаалтан уг сургалтад хамрагдсан.<br><br>Цөмийн энергийн комиссын 2022 оны хуралдаанаар хэлэлцэх асуудалд Цөмийн энергийн тухай хуулийн 15.2.3. “цацраг идэвхт ашигт малтмал импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах болон цацраг идэвхт ашигт малтмал ашигласны дараа газар нөхөн сэргээх” тусгай зөвшөөрөл боловсруулах ажилд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах саналыг 2022 оны 01 дүгээр сарын 25 ны өдөр e.nyamjav@nea.gov.mn email-ээр хүргүүлсэн.<br><br>Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын үе шат:<br><br>1. 2022 оны эцсийн байдлаар Цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын 5 тусгай зөвшөөрөл /XV-021700, XV-018243, XV-018247, XV-007856, XV-012685/-ийг эзэмшигч 3 аж ахуйн нэгж /Монгол ураниум ресурс, Зараяа холдингс, Алкалли метал монголиа/ байх ба 2021 онд голчлон баганат өрөмдлөг, цооногийн каротаж, талбайн геофизик, | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | лабораторийн шинжилгээ зэрэг ажлуудыг нийт 690 орчим сая төгрөгийн зардал гаргаж хийж гүйцэтгэсэн байна. | | | |
| 3 | 4 | Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01 | 55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/44 дүгээр тушаалаар батлагдсан “Агентлагийн ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг боловсруулан батлуулсан. Уг хөтөлбөрийн хүрээнд жил бүр төлөвлөгөөг боловсруулан батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.<br><br>Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/46 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмал, газрын тосны газрын албан хаагчдын 2021-2023 онд хэрэгжүүлэх сургалтын хөтөлбөр”-ийг 2 дугаар хавсралтаар боловсруулан батлуулсан. Уг хөтөлбөрийн хүрээнд жил бүр төлөвлөгөөг боловсруулан батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100 | | |
| 6 | 8 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01 | 8.2.1. эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; | Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн А/121 дугаар тушаалаар шинэчлэгдэн батлагдсан тул АМГТГ-ын цахим хуудсанд Агентлагийн эрхэм зорилго, зорилт, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, хэлтэс, нэгжүүдийн үндсэн чиг үүргийг шинэчлэн 2022.07.05-ны өдөр байршуулсан. | 100 | | |
| | 9 | | 8.2.2. чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл | Төрийн захиргааны удирдлагын газар, Хайгуул, ашиглалтын газар, Газрын тос, бүтээгдэхүүний газар, Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Уул уурхай, газрын тосны төв лаборатори тус бүрийн чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, албан хаагчдын | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүргэх нийгмийн сүлжээний хаяг; | албан тушаал, овог нэр, утасны дугаар, өрөөний дугаар, албаны цахим шуудангийн хаягийг тус тус байгууллагын цахим хуудасны Бидний тухай цэсийн Бүтэц, зохион байгуулалт бүлэг дотор 2022 оны 11 дүгээр сард шинэчлэн байршуулсан. Үүнд: /https://mrpam.gov.mn/article/29/ https://mrpam.gov.mn/article/184/ https://mrpam.gov.mn/article/29/ https://mrpam.gov.mn/article/185/ https://mrpam.gov.mn/article/33/ https://mrpam.gov.mn/article/180/ https://mrpam.gov.mn/article/76/ https://mrpam.gov.mn/ Байгууллагын мэдээлэл лавлагааны утас болон мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаягийг байгууллагын цахим хуудасны нүүрэнд байршуулсан. /https://www.facebook.com/AsigtMaltmalGazrinTosniiGazar/ / Байгууллагын байршил, шуудангийн хаяг, жижүүрийн утас, факс зэргийг https://mrpam.gov.mn/ цахим хуудасны нүүрэнд Холбоо барих гэсэн дотор байршуулсан. | | | |
| | 10 | | 8.2.3. эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, | АМГТГ-ын үйл ажиллагааны статистик мэдээллийг ХШҮДАХ-ээс сар бүр шинэчлэн гаргадаг бөгөөд үүнд байгууллагын улсын төсөвт төвлөрүүлсэн орлого,уул уурхайн бүтээгдэхүүний экспорт, түүний үнийн мэдээлэл, газрын тосны бүтээгдэхүүний ашиглалт, импорт, экспортын хэмжээ, үнийн мэдээлэл зэрэг эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлттэй холбоотой мэдээллүүдийг нийтэлж товхимол | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; | байдлаар байгууллагын цахим хуудас болон төрийн нээлттэй өгөгдлийн портал сайтад олон нийтэд нээлттэй, татаж авах боломжтойгоор тогтмол байршуулдаг. Байгууллагын цахим хуудасны Мэдээ, мэдээлэл цэсийн Статистик мэдээ хэсэгт байршуулдаг-https://mrpam.gov.mn/article/177/.<br><br>-Байгууллагын үйл ажиллагааны жил бүрийн тайлан, төлөвлөгөө болон бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тус тус байгууллагын цахим хуудасны Ил тод байдал цэсийн Үйл ажиллагааны ил тод байдлын Тайлан, төлөвлөгөө дотор жил бүр тогтмол нэмж нийтэлдэг- https://mrpam.gov.mn/article/65/.<br><br>-Байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж тус бүрийг байгууллагын цахим хуудасны Ил тод байдал цэсийн Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдал хэсэгт жил бүр шинэчилж тогтмол нийтэлдэг. | | | |
| | 11 | | 8.2.4. хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан; | Одоогоор ямар нэг хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлсэн үнэлгээний ажил холбогдох байгууллагуудаас хийгдээгүй. | - | | |
| | 12 | | 8.2.5. хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан; | Байгууллагын ил тод байдлыг хангаж ажиллах ажлын хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газрын 2021 оны гүйцэтгэлийн тайланг 2022.01.25-ны өдөр, Ашигт малтмал, газрын тосны газрын батлагдсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2022.01.28-ны өдөр, “АЛСЫН ХАРАА – 2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг 2022.11.04-ний өдөр газрын цахим хуудсанд үйл ажиллагааны ил тод байдал булангийн тайлан, | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | төлөвлөгөө хэсэгт хуулийн хугацаанд тус тус байршуулсан. | | | |
| | 13 | | 8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт; | Байгууллагын mrpam.gov.mn сайтын Хууль, эрх зүй цэсэд үйл ажиллагаанд дагаж мөрддөг бүх хууль, тогтоомжийг нийтэд нээлттэй шинэчлэн байршуулсан. | 100 | | |
| | 14 | | 8.2.7. албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг; | ЗГ-ын 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 295 дугаар тогтоолоор агентлагийн орон тооны дээд хязгаар шинэчлэн батлагдсантай холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн “Ашигт малтмал, газрын тосны газрын бүтцийн ерөнхий бүдүүвч, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай” А/269 дүгээр тушаалаар газрын дарга, чиг үүргийн 19 нэгжтэй байхаар өөрчлөн баталсан. Үүний дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/170 дугаар тушаалаар бүтэц, орон тоо шинэчлэн батлагдсан ба албан тушаалын тодорхойлолтууд боловсруулан ажиллаж байна. | 70 | | |
| | 15 | | 8.2.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ; | Тайлант хугацаанд хүний нөөцөд нийт ажилтан, албан хаагч болон бусад байгууллагаас 85 албан бичиг, 153 өргөдөл, хүсэлт ирсэн байна. Үүнээс албан бичгээр хариуг 34 албан бичгээр, 39 цахимаар, 98 тушаалаар, 47 утсаар тухай бүр шийдвэрлэсэн. | 100 | | |
| | 16 | | 8.2.9. хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл; | 2021 оны жилийн эцсийн болон 2022 оны 1-11 дүгээр сарын мэдээг Кадастрын хэлтэс, Ашигт малтмалын хайгуулын хэлтэс, Уул уурхайн хэлтэс, Нүүрс судалгааны хэлтэс, Уул уурхай, газрын тосны төв лаборатори, Газрын тосны ашиглалтын хэлтэс, Газрын тосны бүтээгдэхүүний хэлтэс, Хүнд үйлдвэр, судалгаа, техник, технологийн хэлтэс, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсээс хүлээн авч хянан, нийт | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 6 бүлгийн 50 төрлийн хүснэгт, графиктай 30 хуудас статистик мэдээний эмхтгэлийг нийт 12 удаа боловсруулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, агентлагийн холбогдох 29 албан тушаалтнуудад болон вэб хуудсанд байршуулсан. | | | |
| | 17 | | 8.2.10. мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр | АМГТГ-аас мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөрийн биелэлт одоогоор гараагүй байна. | - | | |
| | 18 | | 8.3.1. ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл; | Тусгай шалгалт /тухайн албан тушаалын/ болон Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтын зарыг веб хуудасны хүний нөөцийн ил тод байдал цэсэд байршуулсан. https://mrpam.gov.mn/article/67/ | 100 | | |
| | 19 | | 8.3.2. албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам; | 2022 оны 11 дүгээр сард АМГТГ-ын веб хуудасны хүний нөөцийн ил тод байдал цэсэд Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт батлагдсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”, “Төрийн албаны зөвлөлийн тогтоол 2020 оны 12 дугаар сарын 2-ны өдөр дугаар 372 дугаар тогтоолын хавсралт журам”-ыг тус тус байршуулсан. https://mrpam.gov.mn/public/pages/68/209632.pdf, https://mrpam.gov.mn/article/68/ | 100 | | |
| | 20 | | 8.3.3. албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм; | 2022 оны 11 дүгээр сард АМГТГ-ын веб хуудасны хүний нөөцийн ил тод байдлын цэсэд Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг байршуулсан. https://mrpam.gov.mn/public/pages/68/209237.pdf | 100 | | |
| | 21 | | 8.3.4. хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам; | 2022 оны 11 дүгээр сард АМГТГ-ын веб хуудасны хүний нөөцийн ил тод байдлын цэсэд АМГТГ-ын даргын 2021 оны 03 дугаар сарын 24-ний А/44 дүгээр | 70 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тушаалаар батлагдсан хөтөлбөрийг байршуулсан. https://mrpam.gov.mn/article/68/ | | | |
| | 22 | | 8.3.5. хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ; | 2022 оны 11 дүгээр сард АМГТГ-ын веб хуудасны хүний нөөцийн ил тод байдал цэсэд байршуулсан. https://mrpam.gov.mn/article/68/ . | 30 | | |
| | 23 | | 8.3.6. албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам. | 2022 оны 11 дүгээр сард АМГТГ-ын веб хуудасны хүний нөөцийн ил тод байдлын цэсэд Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан **"Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"**-ыг байршуулсан. https://mrpam.gov.mn/article/68/ | 100 | | |
| | 24 | | 8.4.1. өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл; | Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор; Байгууллагын веб хуудасны Ил тод байдал цэсэд тухай бүр нийтэлсэн. | 100 | | |
| | 25 | | 8.4.2. төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан; | Байгууллагын веб хуудасны Ил тод байдал цэсэд хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, санхүүгийн тайланг нийтэлсэн. | 100 | | |
| | 26 | | 8.4.3. санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт; | Үндэсний аудитын газраас байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг байгууллагын веб хуудасны ил тод байдал цэсэд нийтэлсэн. | 100 | | |
| | 27 | | 8.4.4. хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын | Байгууллагын веб хуудасны Ил тод байдал цэсэд хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | үйлчилгээний хөлсний хэмжээ; | хэмжээнд өөрчлөлт ороогүй талаарх мэдээллийг тухай бүр 12 мэдээг нийтэлсэн. | | | |
| | 28 | | 8.4.5. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар; | Байгууллагын веб хуудасны Ил тод байдал цэсэд тухай бүр 12 мэдээг нийтэлсэн. | 70 | | |
| | 29 | | 8.4.6. таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; | 2022 оны жилийн эцсийн байдлаар 5 сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 1.2 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй нийт 48 мэдээллийг дараа сарын 8-ны дотор тухай бүр нийтэлсэн. | 100 | | |
| | 30 | | 8.4.7. цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт; | Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын төсөв, санхүүтэй холбоотой тухай бүр 60, сар бүр 20, улирал бүр 3, хагас жилд 4, жилдээ нэг байршуулах 4, нийт 91 мэдээ, мэдээллийг шилэн дансанд байршуулсан бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй нийт 320.7 тэрбум төгрөгийн орлого, 328.7 тэрбум төгрөгийн зарлагын нийт 649.4 тэрбум төгрөгийн гүйлгээний мэдээллийг https://info.shilendans.gov.mn/-д сар бүрийн 08-ны дотор тогтмол нийтлэгдсэн. | 70 | | |
| | 31 | | 8.4.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; | https://info.shilendans.gov.mn/-д бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр байхгүй талаар мэдээг сар бүрийн 08-ны дотор 2022 оны 12 дугаар сарын байдлаар нийт 12 мэдээ, мэдээллийг байршуулсан. | 100 | | |
| | 32 | | 8.4.9. шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч | Ашигт малтмал газрын тосны газрын шилэн дансны хөтлөлт, цахим санд байршуулсан мэдээлэлд дотоод аудит хийхдээ 2022 оны шилэн дансны цахим санд | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл; | оруулсан мэдээлэл, агентлагийн даргын 2022 оны эхний хагас жилийн А-170 ширхэг, Б-158 ширхэг тушаалтай танилцаж, аудитыг хийж гүйцэтгэсэн. Мөн 2022 оны АМГТГ-ын данснуудын хуулгыг СХОХ-ээс гаргуулан авч шилэн дансны цахим санд оруулах мэдээллийг бүрэн гүйцэт цаг хугацаанд нь мэдээлсэн байдалд хяналт тавьж дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн.<br><br>Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалтанд нийцүүлж, агентлагийн даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг чиг үүргээ хангалттай хэрэгжүүлсэн.<br><br>Мөн тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д “Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна” гэсэн заалтын дагуу цахим самбар байршуулж, нээлттэй ил тод мэдээллээр олон нийтийг чөлөөтэй танилцах боломжийг хангаж ажилласан байна.<br><br>Шилэн дансны цахим санд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан хэдий ч засвар хийх, өөрчлөлт оруулах, нэмж мэдээлэл байршуулахад хугацаа хоцорсон төлөвтэй болж программ өөрчлөгддөг. Энэ нь shilendans.gov.mn цахим хуудас төгс боловсронгуй бус байгааг харуулж байна.<br><br>2022 оны хагас жилийн шилэн дансны цахим санд байршуулсан мэдээлэлд дотоод аудит хийж 6 заавар зөвлөмж хүргүүлж ажилласан. СХОХ-ийн албан хаагчид зөвлөмжийг хэрэгжүүлж, тайланд заасан хугацаанд хэрэгжүүлж ажилласан. | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 33 | | 8.4.10. төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; | Төлөвлөгөөнд тусгагдсан 17 нэр төрлийн 924.9 сая төгрөгийн өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээг шууд худалдан авалтаар 8, харьцуулалтын аргаар 5, нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 4 тендерийг зохион байгуулахаар 8 үнэлгээний хороо байгуулагдан ажилласан. Үүнээс гэрээ байгуулагдсан 6, Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн төсөл арга хэмжээ 1, Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсантай холбогдуулан хасагдсан төсөл арга хэмжээ 1 байна. Тендер шалгаруулалттай холбоотой мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем https://tender.gov.mn/-д тухай бүр нийтэлдэг. | 100 | | |
| | 34 | | 8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт; | Ашигт малтмал газрын тосны газар нь 2022 оны Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын худалдан авах ажиллагаагаар "урсгал төсөв", "төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжих хөрөнгө" гэсэн 2 эх үүсвэрээс нийт 17 нэр төрлийн **924,970,400** төгрөгийн өртөг бүхий бараа ажил үйлчилгээний ерөнхий төлөвлөгөөг батлуулж худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулсан.<br><br>Улсын их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.2.6-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор АМГТГ-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцэд орон нутаг дахь төлөөлөгчийн газрыг бүсчилсэн байдлаар зохион байгуулахаар тооцож 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор баталсан "Засгийн газрын орон тооны хязгаар"-т | 70 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | заасан 150 орон тоог 185 гэж баталж Эрдэс баялгийн хэлтсийн худалдан авах ажиллагааны төсвийг тус газрын төсөвт тусгаж баталсан. Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 2022 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн А/104 дүгээр тушаалаар Эрдэс баялгийн хэлтсийн худалдан авах ажиллагаанд төсөвлөгдсөн 266,713,500 төгрөгийн 5 нэр төрлийн бараа ажил үйлчилгээг тус орон тоо бүтэц байгуулагдаагүй байгаа учир худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулаагүй учир дотоод аудит хийгдээгүй болно.<br><br>ХШҮДАХ-ээс 2021 болон 2022 оны худалдан авах ажиллагаанд дотоод аудит хийж зөвлөмжөөр өгөгдсөн, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бүх бараа, ажил үйлчилгээг батлагдсан цаг хугацаанд бүрэн хэрэгжүүлж байх, бараа нийлүүлэх, ажил үйлчилгээг үзүүлэх гэрээг хуулийн хугацаанд үнэлж гэрээ байгуулж хэвших, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49.2.10-т заасан гэрээг дүгнэж, бараа ажил үйлчилгээг хүлээж авсан баримт, материалыг бүрдүүлж архивладаг байх зэрэг 9 зөвлөмж хүргүүлж ажилласан . | | | |
| | 35 | | 8.4.12. мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл; | Одоогоор мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн этгээдийн мэдээлэл байхгүй байна. | - | | |
| | 36 | | 8.4.26. төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж | Гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй 2 төслийн явцын талаар цаг үеийн мэдээллийг тухай бүр байгууллагын цахим хаягт байршуулсан. Мөн УУХҮ- | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн; | ийн сайдын 2021 оны А/63 дугаар тушаалын дагуу 2022 оны сар бүрийн 8-ны дотор гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төслийн явцын мэдээг УУХҮЯ-нд хүргүүлсэн. Мөн Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн 2022 оны хэрэгжилтийн тайланг 2 дугаар сарын 1-ний өдрийн дотор УУХҮЯ-нд тайлагнасан. | | | |
| | 38 | | 8.4.28. хууль тогтоомжид заасан бусад. (8.4.Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана☺ | Одоогоор мэдээлэл байхгүй байна. | - | | |
| | 39 | | 8.5.1. үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл; | https://info.shilendans.gov.mn/, болон байгууллагын веб хуудасны ил тод байдал цэсэд Уул уурхай газрын тосны төв лабораторийн үйлчилгээний хөлсний хэмжээнд өөрчлөлт орсон талаарх мэдээг нийтэлсэн. | 70 | | |
| | 41 | | 8.6.1. олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох | Агентлагийн даргын 2022 оны А/121 дугаар тушаалаар батлагдсан "Хайгуул, уулын ажлын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээг хүргүүлэх, ирүүлэх, хүлээн авах заавар"-г Байгууллагын цахим хуудсаар (https://mrpam.gov.mn/news/2293/) 1 сарын хугацаатай (2022.05-16-ны өдрөөс 06.16-ны өдрийг хүртэл) олон нийтээс санал авах ажлыг эхлүүлсэн бөгөөд 4 ААН- | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал; | ээс ирүүлсэн саналуудыг хэлэлцэж, төсөлд тусгасан. Улмаар захиргааны хэм хэмжээний улсын бүртгэлд бүртгүүлэхээр ХЗДХ-ийн яаманд хүргүүлсэн бөгөөд 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Захиргааны хэм хэмжээний улсын бүртгэлд бүртгэн авснаар нийтээр дагаж мөрдөх хүчин төгөлдөр хэм хэмжээний акт болсон. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөл болон даган гарах хуулийн өөрчлөлтүүдэд санал авах дотоод ажлыг 2023/01/12-ны өдөр эхлүүлсэн бөгөөд 2023/01/20-ны өдөрт багтаан саналыг нэгтгэн ХЗДХЯаманд хүргүүлнэ. | | | |
| 13 | 69 | Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2020-01-09 Дугаар 2020 №02 | УУХҮЯ хуулийн төсөл 2020. Ашигт малтмалын тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг Уул уурхайн салбарын мэргэжлийн холбоодод танилцуулж, санал авах ажлыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газартай хамтран 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулав.<br><br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/273 дугаар тушаалаар Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж, 2022 оны 10 дугаар сарын 31-нээс 12 дугаар сарын 01 хүртэл нийт 10 удаагийн ажлын хэсгийн хуралд оролцож, уг хуулийн төсөл, үзэл баримтлалын төсөл зэргийг боловсруулахад тухай бүр санал өгч ажилласан.<br><br>Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын төслийн Ерөнхий зүйлийн 1.3, 1.6, Ашигт малтмал олборлох өргөдөл гаргах, түүнийг хянан шийдвэрлэх хэсгийн 2.2, 2.8, Бичил уурхай эрхлэгч этгээдийн эрх, үүрэг хэсгийн 3.2.1, 3.2.2, 3.2.10, 3.2.14, Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талбай хэсгийн | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 4.4, Сум, дүүргийн Засаг даргын эрх, үүрэг хэсгийн 6.1.3, 6.1.4, 6.1.9, 6.1.11, 6.1.15, 6.1.17, 6.2, Төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг хэсгийн 9.1.1, 9.1.5, 9.1.6, Талбайг буцааж хүлээлгэн өгөх хэсгийн 12.2, Хяналт тавих, хариуцлага хүлээлгэх хэсгийн 13.1 дэх заалтуудад санал боловсруулж Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газарт 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр хүргүүлэн төсөлд тусгуулж 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай 296 дугаар тогтоолоор батлагдсан. | | | |
| 15 | 72 | Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2020-12-04 Дугаар 2020 №39 | 1.1/. 1.Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай: 1/бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсвийн орлого нэмэгдүүлэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж, бүх салбарын төсвийн шинэчлэлийг эрчимжүүлэх; | Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар АМГТГ-т Урсгал зардлаар 5,196.6 сая төгрөг батлагдсанаас Засгийн газрын 43, 93 дугаар тогтоолын дагуу төсөвт зохицуулалт хийгдэж 5,090.2 сая төгрөг болж буурч батлагдсан. Үүнээс 2021 оны жилийн эцсийн байдлаар урсгал зардал 5,015.03 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Улсын төсөвт төвлөрүүлэх орлого 265,400.0 сая төгрөг батлагдсан бөгөөд 2021 оны жилийн эцсийн байдлаар 268,696.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлээд байна. 2021 оны батлагдсан төсвийн дагуу төсвийн сар, улирлын хуваарийн саналыг УУХҮЯ-нд хүргүүлж батлуулсан бөгөөд батлагдсан сар, улирлын хуваарийн дагуу зарцуулалтыг хийж гүйцэтгэн ажилласан. | 100 | | |
| УИХ-ын байнгын хорооны тогтоол | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 24 | 92 | Засгийн газарт чиглэл өгөх тухай БОХХААБХ/ӨБ Х/ 2019-05-28 Дугаар 2019 №04/01 | 1.1. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн биелэлтийг нийслэл болон Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт хангасан талаар танилцуулах; | Засгийн газрын 2015 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 120 дугаар тогтоол “Гол мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам”-ын дагуу гэрээ байгуулсан 42 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2021 оны гэрээний хэрэгжилтийг 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр 5 талт гэрээний ажлын хэсэг хуралдан дүгнэн, гэрээг сунгалаа.<br><br>Гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах,, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журмын дагуу Засгийн газрын 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 120 дугаар тогтоолын дагуу байгуулсан 52 гэрээний хэрэгжилт, явц, үр дүнг боловсруулж бэлтгэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргад byanbadagva@mmhi.gov.mn цахим хаягаар тус тус 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хүргүүлсэн. | 100 | | |
| | 102 | | 1.5. “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн Байгаль орчны менежментийн 2020 оны төлөвлөгөөний биелэлтийг хангуулах, 2021, 2022 оны төлөвлөгөөг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд яаралтай баталж, хэрэгжилтэд хяналт | Петрочайна дачин тамсаг ХХК 2020 болон 2021 онд хийгдээгүй үлдсэн биологийн нөхөн сэргээлт, өрмийн шингэн хаягдлыг саармагжуулах, хатуу хог хаягдлыг ангилан боловсруулах, ашиглагдахгүй замын хөрсийг суллах, хүрээлэн буй орчны хяналт шинжилгээ, дүйцүүлэн хамгаалах ажил зэрэг байгаль орчны нөхөн сэргээлтийн 17 төслийг хэрэгжүүлсэн. Дорнод аймгийн ЗДТГ болон БОАЖЯ-нд олон удаа албан бичиг явуулж, уулзалт хэлэлцээр хийсний үндсэн дээр ажлын хэсгийг томилуулан өмнөх жилийн байгаль орчны ажлын гүйцэтгэлийг дүгнүүлсэн. | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Дорнод аймгийн ЗДТГ-аас томилогдсон ажлын хэсэг 2022 оны 06 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд талбай дээр хяналт шалгалт хийж, ажлын гүйцэтгэлийг хүлээн авч баталгаажуулсан. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/244 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2022 оны 07 дугаар сарын 05-06-ны өдрүүдэд Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд ажилласаны үр дүнд 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдөр баталсан. | | | |
| | 105 | | 1.8/. Газрын тосны олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанд үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа гүний ус ашиглах технологийг өөрчилж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл багатай, орчин үеийн дэвшилтэд техник, технологийг үе шаттай нэвтрүүлэх; | Петрочайна Дачин Тамсаг ХХК орд газрын олборлолтын үйл ажиллагаанд ашиглах усыг 300-500 метрийн гүнээс авч ашиглаж байгаа ба энэ нь олон улсын орд газрын олборлолт, ус шахалтын ажлын жишигт нийцсэн байдаг. Гүний ус агуулж буй давхарга нь үндсэн 3 бүсэд хуваагдана. 100 метр хүртэлх гүний ус нь ард иргэдийн ахуйн хэрэгцээ болон мал амьтныг ундаалах ус байдаг. Орд газрын хэрэгцээнд өрөмдсөн худгийн гүн нь 400-500 метр байна. Үйлдвэрлэлийн зориулалтаар авч ашиглаж буй усны давхарга нь 300 метрээс доош гүнд байгаа тул ард иргэдийн ахуйн хэрэгцээний усанд нөлөөлөхгүй. 2019 оны 08 дугаар сард Тамсаг XXI талбайн 5 цооногт полимер шахалтын технологийг нэвтрүүлсэн ба уг 5 цооногийн ойролцоох олборлолтын 24 цооногийн олборлолтын өөрчлөлтийг полимер шахалтын дараах 4 сарын байдлаар судлан үзвэл олборлолт 11 цооногт дунджаар 43 хувь өссөн. | 100 | | |
| | 106 | | 1.9/. Газрын тосны хайгуул, олборлолтын үеийн үйл ажиллагаанаас үлдсэн чанарын шаардлага хангахгүй, | Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх Түр зөвшөөрөл бүхий "Элемент" ХХК Тосон-Уул XIX талбайд хуримтлагдсан хугацаа хэтэрсэн химийн бодисыг устгах ажлыг гүйцэтгэж байгаа ба | 70 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | устгах шаардлагатай химийн бодисын хог хаягдлыг олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргийн дагуу шийдвэрлэх; | 2022.09.25-ны өдрөөс 2022.10.25-ны өдрийн хооронд нийт 20 удаагийн тээвэрлэлтээр 592 тонн химийн бодисыг Налайх дүүрэгт байрлах өөрийн үйлдвэр рүү тээвэрлэж дууссан. Агуулах, талбайг чөлөөлж, Петрочайна Дачин Тамсаг ХХК-д хүлээлгэн өгсөн. | | | |
| | 107 | | 1.10. Газрын тосны экспортын тээвэрлэлтийг шороон замаар хийж байгаагийн улмаас тухайн орон нутгийн байгаль орчин, бэлчээр ихээр сүйдэж, тоосжилт үүсч байгаа тул хатуу хучилттай автозамын барилгын ажлыг яаралтай дуусгах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээг авах; | Тамсаг XXI талбайгаас Тосон-Уул XIX-Баянхошууны хилийн боомтын чиглэлийн хатуу хучилттай авто замд холбох “Өмнөд Буйр” (58.5 км хатуу хучилттай авто зам, төсөв нь 18,380,000 ам.доллар) төслийг гүйцэтгэгчээр “Их монгол барилга” ХХК шалгарч, “Петрочайна дачин тамсаг” ХХК-тай DQYT-2018-JSGC-4132 дугаар гэрээг байгуулан, 2019 оны 04 дүгээр сараас эхлэн ажлаа гүйцэтгэж байна. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар замын бүтээн байгуулалтын ажил 71.5 хувьтай, санхүүжилт 70.8 хувьтай байна. Үүнд асфальтан хатуу хучилт 36 км замд, замын 2 дугаар үеийн ажил 37.2 км, 1 дүгээр суурын ажил 58.5 км замд, зураг төслийн дугуу 34 ус зайлуулах хоолойг бүрэн хийсэн. “Өмнөд Буйр” төсөл нь цар тахлын улмаас хил гаалиар бараа материал нэвтрэх боломж хязгаарлагдсан тул хугацаа алдаж, үнийн өсөлтийн зөрүү үүссэн. Захиалагч, гүйцэтгэгч талууд үл ойлголцолд хүрч, ажил удааширсантай холбогдуулан Газрын тос, бүтээгдэхүүний газрын дарга Б.Түвшинжаргал, Газрын тосны ашиглалтын хэлтсийн дарга С.Түвшинбаяр, захиалагч, гүйцэтгэгч талын төлөөллүүдийг байлцуулан 2022 оны 08 дугаар сарын 16, 19, 23-ны өдрүүдэд уулзалтыг зохион байгуулсан. Үүний үр дүнд 2022 оны 08 дугаар сарын 23-ны өдөр “Өмнөд Буйр” төсөлд тулгараад байгаа асуудал дээр харилцан зөвшилцөлд хүрч Захиалагч, Гүйцэтгэгч талууд санамж бичиг байгуулсан. “Их монгол барилга” ХХК-д шаардлага хүргүүлэх тухай 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 1/4120 | 70 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дугаар, “Петрочайна дачин тамсаг” ХХК-д шаардлага хүргүүлэх тухай 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 1/4121 дугаар албан бичгийг тус тус хүргүүлсэн. | | | |
| | 108 | | 1.11/. “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн зүгээс нийгмийн хариуцлагын хүрээнд тухайн орон нутгийн тогтвортой хөгжлийн бодлогыг дэмжих, хамтын ажиллагааг өргөжүүлэх, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох байгууллагатай хамтран ажиллах; | 2022 оны 09 дүгээр сард Петрочайна дачин тамсаг ХХК нь 2021, 2022 оны Байгаль орчныг хамгаалах орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх гэрээг Матад болон Халхгол сумтай байгуулсан.<br><br>Орон нутгийг дэмжих сангийн төлбөр болох талбай тус бүрийн 250000 ам.долларыг төлсөн. Үүнээс талбай тус бүр Дорнод аймгийн ЗДТГ-т 200000 ам.доллар, Матад сумын ЗДТГ-т 50000 ам.доллар, Халхгол сумын ЗДТГ-т 50000 ам.долларыг тус тус шилжүүлсэн (2022.09.27,28）<br><br>Матад суманд 2018-2020 оны Байгаль орчныг хамгаалах орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх гэрээний дагуу бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 184,854.52 ам.долларын ажил хийсэн байна. Үүнээс Зөөлөн чулуун хийц ХХК-ийн Матад сумын наадмын талбайн барилгын ажилд нийт төлбөрийн 50% буюу 72,203.86 ам.доллар (2022.10.26), Тосон мөрөн ХХК-ийн хогийн цэгийн болон төрийн албан хаагчийн орон сууцны ажилд 112,650.66 ам.долларыг зарцуулсан байна (222.12.21). Бүтээн байгуулалтын ажлын явц:<br>-Матад сумын наадмын талбайн ажил 20 хувьтай<br>-Хогийн цэгийн барилгын ажил 10 хувьтай<br>-Төрийн албан хаагчийн 2 айлын орон сууцыг барьж хүлээлгэн өгсөн байна.<br><br>Халх гол суманд 2018-2020 оны Байгаль орчныг хамгаалах орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх гэрээний дагуу бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 527,600 ам.долларын ажил хийсэн байна. Үүнээс 2022 онд Тосон мөрөн ХХК-ийн хийж буй барилгын | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | бүтээн байгуулалтын ажлын зардалд 364,472.64 ам.долларыг зарцуулсан байна. Бүтээн байгуулалтын ажлын явц:<br>- Ялалт багийн даргын болон эмнэлгийн байрны барилгын ажлыг дуусган хүлээлгэн өгсөн<br>- 80 айлын орон сууцны гадна болон дотор сантехникийн шугам сүлжээг шинэчилж дуусгасан байна. | | | |
| | 109 | | 1.12/. “Петрочайна Дачин Тамсаг” ХХК болон туслан гүйцэтгэгч компаниудад ажиллаж байгаа Монгол Улсын иргэдийн тоог нэмэгдүүлэх, сургах, дадлагажуулах, мэргэшүүлэх ажлыг холбогдох төрийн байгууллагатай хамтран зохион байгуулах. | Петрочайна дачин тамсаг ХХК Дорнод аймгийн Политехникийн коллежтэй хамтран Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны сургалтыг 2022.10.26-29-ний өдрүүдэд зохион байгуулж, Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн бүх ажилчдыг сургалтанд хамруулсан.<br><br>2022 онд Тосон-Уул XIX талбайд хөдөлмөрийн гэрээтэй Монгол ажилчдын тоо 301 байна. Засгийн газрын тогтоолын дагуу 25 ажилтан тутамд 1 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах ёстой бөгөөд энэ талбайд хөгжлийн бэрхшээлтэй 12 иргэнийг ажиллуулах ёстойгоос 11 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулж, 4 иргэнд халамж төлж байна. Нийт 20,160,000 төгрөгийг халамжийн зардалд төлсөн байна.<br><br>2022 онд Тамсаг XXI талбайн Монгол ажилчдын тоо 251 байсан ба Засгийн газрын тогтоолын дагуу 25 Монгол ажилчдад 1 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байх ёстой ба ажилд авах ёстой хөгжлийн бэрхшээлтэй иргэн 10 байх ёстой юм. Тамсаг XXI талбай нь хөгжлийн бэрхшээлтэй 8 иргэнийг авч ажиллуулсан, үлдсэн 2 хүний төлбөрийг журмын дагуу төлсөн. Нийт 10,080,000 төгрөгийг төлсөн. | 100 | | |
| | 111 | | 2. “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн 2014-2018 онд батлагдсан | Үндэсний аудитын газартай хамтран ажлын хэсэг байгуулж ажиллаж эхэлсэн. Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн | 100 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг баталгаажуулах аудитыг нэн яаралтай дуусгаж, холбогдох Байнгын хороонд танилцуулахыг Үндэсний Аудитын газарт даалгасугай. | 2014-2018 оны өртөг нөхөгдөх зардлыг баталгаажуулах ажлыг Үндэсний аудитын газартай хамтран ажлын хэсэг байгуулж, 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн ажилласан.<br><br>Аудитын ажлын хүрээнд Үндэсний аудитын газраас шаардсан баримт, материалыг тухай бүрт нь аудиторуудад хүргүүлж ажилласан ба 2014-2018 оны газрын тосны олборлолтын өдөр тутмын мэдээ, задгай олборлолтын мэдээ, газрын тосны ачилтын мэдээ, буулгалтын мэдээ зэрэг нийт 778 боть материал, 2014, 2015, 2016, 2017, 2018 оны жилийн ажлын уулзалтын үр дүнд байгуулсан протоколын хуулбар, 478 цооногийн товч мэдээлэл, өрмийн үр дүнгийн тайланг хүргүүлсэн.<br><br>Газрын тосны экспорт, ачилт, буулгалт, борлуулалтын үйл ажиллагаанд Газрын тосны ашиглалтын хэлтэс болон Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн албан хаагчдын ажлын уялдаа холбоо, хэлтсүүдээс гарах мэдээлэл, тооцооллын аргачлалын талаар аудиторуудад тайлбарлаж, мэдээллээр ханган ажилласан. Түүнчлэн газрын тосны олборлолт, экспортын үйл ажиллагаанд тавьж буй хяналтын талаар танилцуулга мэдээлэл бэлтгэж, аудиторуудад цаасан болон цахим шуудангаар хүргүүлсэн.<br><br>Газрын тосны нөөц батлуулсан тушаал, нөөцийн хөдөлгөөний тайлан, орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, 2014-2018 оны ажлын төлөвлөгөө, төсөв, ажлын гүйцэтгэлийн тайлан, Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийн тайлан, жилийн уулзалтын протоколын хуулбарыг өгсөн. | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Үндэсний аудитын газар аудитын дүгнэлтийг гаргаж, 1 төлбөрийн акт, 2 албан шаардлагыг Петрочайна Дачин Тамсаг ХХК-д хүргүүлсэн. | | | | |
| | 112 | | 1.2/. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээг хийснээс хойших хугацаанд Монгол Улсад оруулсан хөрөнгө оруулалт, үр ашиг, өгөөжийг тооцох, "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-ийн үйл ажиллагаанд экспертийн дүгнэлт гаргах үүрэг бүхий холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулсан ажлын хэсгийг томилж, ажиллуулах; | "Петрочайна дачин тамсаг" ХХК-тай байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээг дүгнэх, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх асуудлыг судалж, санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг мэдээллээр хангах Ажлын дэд хэсэг Монгол Улсын Шадар сайдын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 51 дугаартай тушаалаар байгуулагдсан.<br><br>Ажлын дэд хэсэг нь 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс 06 дугаар сарын 22-ны өдөр хүртэлх хугацаанд 4 удаа хуралдсан бөгөөд 06 дугаар сарын 15-ны өдрөөс 19-ний өдрүүдэд ажлын дэд хэсгийн зарим гишүүд Дорнод аймгийн нутгийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, бүтээгдэхүүн хуваах гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх асуудлыг судалж, Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн үйл ажиллагаатай газар дээр нь танилцсан. Ажлын дэд хэсэг саналаа 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр Шадар сайдаар ахлуулсан ажлын хэсэгт хүргүүлж, 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр танилцуулсан.<br><br>Үүнд гэрээлэгчийн үйл ажиллагааг сайжруулах, бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх ажлын хүрээнд авах арга хэмжээ, газрын тосны салбарт цаашид хөгжүүлэх талаар авах арга хэмжээнүүдийг санал болгосон. Нэмэлтээр Бүтээгдэхүүн хуваах гэрээт Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд батлуулсан газрын тосны нөөцийн тайлан, газрын тосны ордыг ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх боломж, техник технологийн нөхцөл байдалд дүгнэлт гаргах, хөрөнгө | 70 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | оруулалт, өртөг нөхөгдөх зардал, санхүүгийн шалгалт, татварын асуудлаар дүгнэлт гаргах, газрын тосны олборлолт, ашиглалтын үйл ажиллагааны үед байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг багасгах, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт, орон нутагтай хамтарч ажиллах талаар дүгнэлт гаргах, зөвлөмж боловсруулах хөндлөнгийн мэргэшсэн зөвлөхийн ажлын даалгаврыг боловсруулсан. Бүтээгдэхүүн хуваах гэрээ шинэчлэх асуудлыг Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. ЗГ-аас гэрээ хэлцэл хийж эхлэх чиглэлийг Шадар сайдад өгсөн. | | | |
| 28 | 114 | Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58 | 2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай. | Засгийн газрын 2015 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 120 дугаар тогтоол “Гол мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журам”-ын дагуу гэрээ байгуулсан 42 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2021 оны гэрээний хэрэгжилтийг 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр 5 талт гэрээний ажлын хэсэг хуралдан дүгнэн, гэрээг сунгалаа.<br><br>Гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах,, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журмын дагуу Засгийн газрын 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 120 дугаар тогтоолын дагуу байгуулсан 52 гэрээний хэрэгжилт, явц, үр дүнг боловсруулж бэлтгэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргад byanbadagva@mmhi.gov.mn | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | цахим хаягаар тус тус 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хүргүүлсэн. | | | |
| 29 | 115 | Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43 | 1.4. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс зохион байгуулж буй албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтад өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхийг бүрмөсөн хориглох; | АМГТГ нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс зохион байгуулж буй албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтад өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхийг бүрмөсөн хориглох шийдвэрийг мөрдөж ажиллаж байна. | 100 | | |
| | 116 | | 2. Нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллага архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад санаачилгатай оролцох, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриалсугай. | АМГТГ-ын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 10.2.5, 10.2.7, 10.2.8 дах хэсэгт ажлын байранд архи, согтууруулах ундаа хэрэглэхгүй байх заалтыг тусгасан. Албан хаагчдын эрүүл мэнд, хамт олны эерэг уур амьсгал, спортоор хичээллэхийг уриалж АМГТГ-ын албан хаагчид Даваа гараг бүр 18:00-20:00 цагийн хооронд “Сити” их сургуулийн зааланд спортоор хичээллэж, идэвх санаачилгатай оролцож байна. | 100 | | |
| 30 | 117 | Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай | 2. Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын | АМГТГ-ын хурлын заал болон удирдах албан тушаалтнууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг өөрсдийн өрөөнд дээдлэн залсан. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2022-07-11 Дугаар 2022_159 | байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай. | | | | |
| 37 | 126 | Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7 | 5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн | Ашигт малтмал, газрын тосны газар нь Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд байгууллагын гадна хаяг болон УУГТТЛ, АМГТГ-ын Төлөөлөгчийн газрын хаягийг тус бүр монгол бичиг болгож шинэчилсэн. Мөн удирдах албан тушаалтнууд өөрсдийн нэрийн хуудсаа монгол бичгээр шинэчлэн өөрчилж албан хэрэгцээндээ ашиглаж байна. 2023 оны 1 дүгээр сарын 16-аас эхлэн ажлын долоон өдөр 10:00-12:00 цаг хүртэл хурлын зааланд, хэлтэс тус бүрийн тайлан төлөвлөгөө хариуцсан мэргэжилтнүүдийг монгол бичгийн сургалтад хамруулах ажлыг зохион байгуулсан. | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх. | | | | |
| 41 | 130 | Жагсаалт шинэчлэн батлах тухай 2022-05-31 Дугаар 2022_215 | 2. “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг импортлох, экспортлох хилийн боомтын жагсаалт”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай. 2. Хилийн зарим боомтоор шинээр тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг импортлох, экспортлох хэрэгцээ, шаардлагын талаарх мэдээллийг боомт бүрээр бэлтгэж, дипломат шугамаар хөрш улсуудтай харилцаж, хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлэхийг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон нарт тус тус үүрэг болгосугай. | Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 149 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон үндсэн түүхий эдийг импортлох, экспортлоход улсын хилээр нэвтрүүлэх, дамжин өнгөрүүлэх хилийн боомтын жагсаалт”-д Өмнөговь аймгийн Шивээхүрэн боомт, Дорноговь аймгийн Ханги боомт, Ховд аймгийн Булган боомт, Дорнод аймгийн Эрээнцав боомт, Баян-Өлгий аймгийн Цагааннуур боомтыг нэмж оруулахтай холбоотой дээрх 5 боомтоор тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл болон үндсэн түүхий эдийг импортлох хэрэгцээ, шаардлагын талаар товч танилцуулга бэлтгэж 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын ахлах шинжээч Б.Дашбалд цахим шуудангаар хүргүүлсэн. Улмаар Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн “Жагсаалт шинэчлэн батлах тухай” 215 дугаар тогтоолоор “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг импортлох, экспортлох хилийн боомтын жагсаалт”-ыг шинэчлэн баталсан.<br><br>Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6-д заасан “Тэсэрч дэлбэрэх бодис, | 70 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн нэгдсэн сан хөтлөхтэй холбогдсон журам"-ын төсөл, "Журам батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төслийг танилцуулгын хамт тус тус бэлтгэж Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газарт 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр цахим шуудангаар хүргүүлсэн. Улмаар тус журам Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэгдэн батлагдсан.<br>Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн мэдээллийн нэгдсэн сангийн цахим системийг Гүрэн софт ХХК-иар хийлгэсэн ба тус системийн туршилтын ажлыг 5 аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлж, гарсан алдаа болон бусад шаардлагатай засвар сайжруулалтын ажлуудыг Гүрэн софт ХХК-иар хийлгэж байна. | | | |
| 45 | 135 | Бүтээгдэхүүн хуваах гэрээ цуцлах эрх олгох тухай 2022-09-05 Дугаар 2022_337 | 4. Бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцлах ажлыг зохион байгуулж төлбөрийн үлдэгдлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг Ашигт малтмал, газрын тосны газар (Л.Баярмандал)-т, бүтээгдэхүүн хуваах гэрээг цуцлахтай холбогдсон үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт тус тус даалгасугай. | Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 337 дугаар тотоолоор эрх олгосны дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 109 дүгээр тушаалаар Газрын тосны хайгуулын Хар-Ус II, Номгон IX, Дарьганга XXIV, Хэрлэнтохой XXVIII талбайнуудад байгуулсан БХГ-г цуцалсан. Мөн Ашигт малтмал, газрын тосны газрын 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 2/5626, 2/5627, 2/5628, 2/2659 дугаар бичгээр БХГ-ний дагуу төлөх төлбөр урамшууллын үлдэгдлийг төлж барагдуулах талаар мэдэгдсэн. | 100 | | |
| 51 | 146 | Ашигт малтмал хайх талбайн солбицол | 2. Энэ тогтоолын хавсралтад заасан Эрдэнэтийн стратегийн | Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн "Ашигт малтмал хайх талбайн солбицол | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | батлах, эрх олгох тухай 2022-10-19 Дугаар 2022_379 | ордын талбайд ашигт малтмал хайх эрхийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т олгох арга хэмжээг авч, ашигт малтмалын кадастрын зураг зүйн бүртгэл, мэдээллийн санд бүртгэхийг Ашигт малтмал, газрын тосны газар (Л.Баярмандал)-т үүрэг болгосугай. 3. Ашигт малтмал хайх ажлыг гүйцэтгэх төрийн өмчит хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Орхон, Булган аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | батлах, эрх олгох тухай” 379 дүгээр тогтоол, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 03/2885 тоот албан бичгийг тус тус үндэслэн Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн “Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай” А/135 дугаар тушаал гарсан. Улмаар Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 69 дүгээр шийдвэрээр Засгийн газрын тогтоолын хавсралтаар батлагдсан солбицол бүхий Орхон, Булган аймгуудын Орхон, Баян-Өндөр, Жаргалант, Бугат, Сэлэнгэ, Хангал сумдын нутагт байрших Хужир, Хөх асгат, Согоот, Зөөхийн гол, Ундрах, Оюут нэртэй газруудад ашигт малтмалын хайгуулын XV-022166, XV-022167, XV-022168, XV-022169, XV-022170, XV-022171 дугаартай тусгай зөвшөөрлүүдийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т олгосон болно. | | | |
| 50 | 145 | Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц тогтоох тухай 2022-10-19 Дугаар 2022_378 | 2. Энэ тогтоолын хавсралтад заасан газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөцийг 2023 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор бүрдүүлэх арга хэмжээ авч, нөөцийн бүрдүүлэлт, бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж ажиллахыг | Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 378 дугаар тогтоолоор 2023 онд нэр бүхий 54 аж ахуйн нэгж нийт 132,700 тонн газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэхээр баталсан. Үүний дагуу эдгээр аж ахуйн нэгжүүдэд гэрээний үлгэрчилсэн загварыг хүргүүлсэн бөгөөд холбогдох гэрээний хавсралтад дурдсан агуулахын байршил, нөөц бүрдүүлэх тоо хэмжээг нягтлан, | 30 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Ашигт малтмал, газрын тосны газар (Л.Баярмандал)-т тус тус даалгасугай. | тулгалт хийж, гэрээг баталгаажуулахад бэлэн болгоод байна. | | | |
| 99 | 225 | 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдөр 40 дүгээр тэмдэглэл 2022-08-10 Дугаар 2022_40 | XIII.9. . Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн өнөөгийн нөхцөл байдал, тусгай зөвшөөрлийг олгох цахим технологид суурилсан сонгон шалгаруулалтын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн өнөөгийн нөхцөл байдал, тусгай зөвшөөрлийг олгох цахим технологид суурилсан сонгон шалгаруулалтын талаарх саналыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд оруулах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгав. | Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн өнөөгийн нөхцөл байдал, нийт газар нутгийн хэмжээнд олгосон тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээг аймаг, сум тус бүрээр нь гаргаж, тусгай зөвшөөрлийг цахимаар олгох талаар холбогдох мэдээг нэгтгэж Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд өгсөн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд холбогдох саналыг танилцуулж улмаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар “Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” зөвлөмжийг гаргасан. | 100 | | |
| 112 | 256 | Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг | 1. 1.1. “”Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, “Шинэ | “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогын гол агуулга, хүрэхээр зорьж буй үр дүн, Засгийн газраас гарч буй бодлого шийдвэрийн уялдаа холбоо, агуулгыг Уул уурхай, | 100 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | сурталчлан таниулах тухай 2022-07-05 Дугаар 2022_6 | сэргэлтийн бодлого”-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харъяа байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулах; 1.2.””Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хэрэгжилтийн явцын талаар иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг салбарынхаа хэмжээнд зохион байгуулах; | хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газрын албан хаагчдад таниулж, байгууллагын үйл ажиллагаа, төлөвлөгөөгөө энэхүү бодлоготой уялдуулахад нь чиглүүлэх зорилготой сургалтыг Удирдлагын академитай хамтран зохион байгуулж нийт 130 албан хаагч хамрагдаж сертификат авсан.<br><br>1.2. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30 өдрийн 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх сурталчлан таниулах ажлын хүрээнд Эрдэс баялгийн салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлаар 18 аймгийн удирдлагууд, тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдтэй уулзалт хийж “Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, хамтын ажиллагаа, боломж, шийдэл” хэлэлцүүлгийг 2022.03.21-ний өдрөөс 2022.05.02-ны өдрүүдэд АМГТГ-аас зохион байгуулж, тулгамдаж буй асуудлаар санал солилцож ажилласан. | | | |
| Нийт дундаж үнэлгээ: | | | | | 88.8 | | |

---oOo---